

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 04 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.11 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийг үндэслэн Үндэсний статистикийн хорооноос 2021 оны үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/403 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолын дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас “Статистикийн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Үндэсний статистикийн хорооны 2021 оны тайлан”-д дараах асуудлын хүрээнд шинжилгээ хийсэн болно. Үүнд:

1. Үндэсний статистикийн хороо нь Статистикийн тухай хууль тогтоомжид заасан чиг үүргээ 2021 онд хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар;
2. Үндэсний статистикийн хорооноос 2021 оны үйл ажиллагаандаа хийсэн системчилсэн үнэлгээний талаар;
3. Улсын Их Хурлаас баталсан хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийн талаар зэрэг болно.

Нэг.Үндэсний статистикийн хороо нь 2021 онд Статистикийн тухай хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар:

Үндэсний статистикийн хороо (цаашид “ҮСХ” гэх) нь Статистикийн тухай хууль, Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний дагуу шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай статистикийн мэдээллийг эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчлэх зорилгыг дэвшүүлэн 5 зорилтын хүрээнд 2021 оны үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ.

Статистикийн хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу тус хорооны үндсэн чиг үүргийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дараах байдлаар авч үзлээ.

1.1.Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж мөрдүүлэх:

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.7-д “статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж, мэдүүлэх” гэж заасны дагуу ҮСХ нь албан ёсны болон захиргааны статистик мэдээ,

тооллого, судалгааны мэдээлэл цуглуулж, нэгтгэхэд 78 аргачлал, 541 маягт, түүнийг нөхөх заавар, 11 ангиллыг баталж, зөвшөөрөн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

ҮСХ нь 2021 онд 2 ангилал, 6 аргачлал, 16 багц асуулга, маягт, түүнийг нөхөх зааврыг баталснаас “Улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, код”, “Ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны ангилал” бүхий 2 ангилал, 5 аргачлал, 6 багц агуулга, маягт, нөхөх зааврыг шинээр боловсруулан батлуулсан байна. Түүнчлэн статистикийн 6 багц бүтээгдэхүүний тооцоог шинэчилсэн байна.

1.2. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээлэл, тооллого, судалгааг зохион байгуулах, үр дүнг боловсруулах, тархах:

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасны дагуу ҮСХ нь албан ёсны болон захиргааны статистикийн үйл ажиллагааг төвлөрсөн удирдлагаар хангах, мэдээллийн хамралт, үнэн зөв байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, биелэлтэд нь хяналт тавих чиг үүргийн хүрээнд 2021 онд дараах ажлын гүйцэтгэжээ.

ҮСХ нь албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлтийг тооцох мэдээллийг анхан шатны бүртгэл, захиргааны болон албан ёсны мэдээ, тооллого, түүвэр судалгаагаар боловсруулах хүрээнд цуглуулсан мэдээллийн 71.9 хувь нь яам, агентлаг, төрийн бусад байгууллагаас цуглуулсан, 29.1 хувь нь аймаг, нийслэл, дүүргийн газар, хэлтсээр дамжуулан цуглуулсан мэдээлэл байна.

Мөн 2021 онд Коронавирусын халдвар, цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан тооллого, судалгааны мэдээллийг цахим хуудаст суурилсан асуулгын аргаар мэдээлэл цуглуулж, Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.5-д заасны дагуу цар тахлын нөлөөлөл, бизнесийн төлөв байдал, хандлага, инновац, судалгаа хөгжүүлэлтийн мэдээлэл, мэдээллийн технологи, өгөгдлийн сан, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийг цуглуулан “Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 2021 оны ээлжит тооллого”, мал, амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлт, мал сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үзүүлэлтийг гаргах зорилгоор “Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн жилийн эцсийн тооллого”-ыг тус тус улсын хэмжээнд зохион байгуулсан байна.

Түүнчлэн 27 түүвэр судалгааг явуулсан бөгөөд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 6 судалгааг гүйцэтгэсэн байна.

Эдгээр түүвэр судалгаанаас анх удаа зохион байгуулж буй 6 судалгаа, тодорхой давтамжтай явуулж буй 15 судалгаа, “ААН-ийн үнийн хүлээлтийн судалгаа”, “Иргэдийн инфляцын хүлээлтийн судалгаа”, “Худалдан авалтын менежерийн судалгаа”, “Бизнесийн түүвэр судалгаа” зэрэг бусад 4 судалгааг гүйцэтгэсэн байна.

Тооцоо, судалгаа шинжилгээний хүрээнд “Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцооны суурь шинэчлэлт”, “Нийгмийн тооцооны матриц”, “Байгаль орчин, эдийн засгийн дансны систем”, “Хүн амын 2020-2050 оны шинэчилсэн хэтийн тооцоо”, “Хүн амын боловсролын 2020-2050 оны хэтийн тооцоо”, “Ядуурлын тооцоо”-ны суурь түвшинг шинэчлэн, олон нийтэд мэдээлж ажилласан байна.

ҮСХ-ноос тооллого, судалгааны мэдээлэлд албан ёсны болон захиргааны статистикийн мэдээг боловсруулан эдийн засаг, нийгмийн үзүүлэлтээр судалгаа шинжилгээний 12 ажил, хөдөлмөрийн бүтээмжийн 2020, 2021 оны жил, улирлын дэлгэрэнгүй танилцуулга, ДНБ-ын жил, улирлын дэлгэрэнгүй танилцуулга, хүн ам,

хөдөлмөр, эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, хөдөө, аж ахуй, аж үйлдвэр, инфляц, үнийн өөрчлөлт зэрэг 28 салбарын танилцуулгыг бэлтгэж, хэрэглэгчдэд мэдээлсэн байна.

1.3.Мэдээлэл тархаалтын олон улсын стандартад нийцсэн тогтолцоог бүрдүүлэх:

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.11-д “статистикийн мэдээлэл, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тархаах, статистикийн мэдээллийн ил тод байдлыг хангах” гэж заасны дагуу Монгол Улсын нийгэм, эдийн засгийн сар бүрийн танилцуулга, статистикийн жилийн эмхэтгэл, 15 аймгийн Хүн, ам орон сууцны 2020 оны тооллогын үр дүн, тооллогын үр дүнгээр 13 сэдэвчилсэн судалгаа, 25 судалгааны үр дүн, Монгол Улс 100 жилд эмхэтгэл, ном, сэтгүүл, инфографик зэрэг нийт 171 мэдээллийг цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан мэдээллээр хангаж ажилласан байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болон www.1212.mn цахим хуудасны хандалт 2021 онд 1.5 саяд хүрч өмнөх оныхоос 19.2 хувь, www.nso.mn цахим хуудасны хандалт 337.4 мянгад хүрч өмнөх оныхоос 49.9 хувь, фэйсбүүк хуудасны хандалт 3.5 саяд хүрч өмнөх оноос 15.3 хувиар тус тус өссөн байна.

Түүнчлэн статистик мэдээллээр хэрэглэгчдэд үйлчлэхээс гадна хэрэглэгчдийн статистик боловсролыг дээшлүүлэх, мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой байлгах үүднээс мэдээлэл тархаалтыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн сайжруулах чиглэлээр 2021 онд дараах ажлуудыг хийжээ.

- Статистикийн мэдээлэгч, хэрэглэгчдэд үйл ажиллагаагаа сурталчлах, статистикийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр байгууллагын брэнд номыг шинэчлэн боловсруулсан;
- Хэрэглэгчдэд статистикийн мэдээллийг авахад хялбар, ойлгомжтой болгох зорилгоор Статистикийн мэдээллийн сан болон ҮСХ-ны албан ёсны цахим хуудсыг нэгтгэн хэрэглэгчдэд зориулсан талбар, хэрэглэгчдийн сонголт, туршлагад суурилсан (UI/UX) платформыг нэвтрүүлэн ажилласан;
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн бүтцийг Коронавируст цар тахлын нөхцөл байдал, Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, хүн ам, гэр бүл, залуучууд, жендэрийн үзүүлэлтээр хянах самбарыг бэлтгэн шинэчлэн байршуулсан;
- Статистикийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор “Мэргэжилтнээс сонсоё”, “Бидний бахархал”, “Сонирхолтой статистик” болон түүхэн контентуудыг бэлтгэн хэрэглэгчдэд хүргэсэн байна.

Төрийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг хянах зорилгоор “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн хяналтын дашбордыг үндсэн 73 үзүүлэлтийн 2020 оны тоон мэдээллийг холбогдох төрийн 17 байгууллагаас авч нэгтгэн ЗГХЭГ-ын хүсэлтээр нэгдсэн системд байршуулсан байна.

1.4.Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх:

ҮСХ нь 2021 онд мэдээллийн ачааллыг бууруулах, мэдээллийн давхардлыг арилгаж, төсвийн зардлыг хэмнэх, статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах “Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн их өгөгдлийг бодлогын шийдвэрт ашиглах

нь” төслийн баримт бичиг, танилцуулгыг санаачлан боловсруулсан нь төрийн байгууллагуудад байгаа салангид өгөгдлүүдийн уялдаа сайжирч, мэдээллийн хүрээ, ашиглалт нэмэгдэх, нууцлал, аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэх эхний алхам тавигдсан байна.

Статистикийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төлөвлөсөн хугацаанд мэдээ тайланг цуглуулж, боловсруулан тархаахын тулд мэдээ тайлан ирүүлэх график батлуулан ажиллаж байгаа нь яам, агентлаг, түүний харьяа газар нэгжүүдээс мэдээллийг хугацаанд нь цуглуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Хуулийн хүрээнд мэдээлэл цуглуулах арга, хүртээмжийг сайжруулсан ч мэдээллийн үнэн зөв гэдгийг хэрхэн тусгасан талаар болон мэдээлэгчээс мэдээлэл авах хугацаа болон нийтэд мэдээлэх хугацааг албан ёсоор товлосон талаар тайланд тусгагдаагүй байна.

Хоёр.Үйл ажиллагааны тайланд системчилсэн үнэлгээ хийсэн эсэх:

ҮСХ нь 2021 оны ажлынхаа тайланд системчилсэн үнэлгээ хийхдээ “Албан ёсны статистикийг хөгжүүлэх 2017-2020 дунд хугацааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайлан, Үндэсний статистикийн хорооны 2020 оны үйл ажиллагааны тайлан болон холбогдох бусад баримт материалыг хамруулж, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалын 2.5-д заасан “байгууллагын чиг үүргийн хэрэгжилт”, “хүний нөөц”, “байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа” гэсэн системчилсэн үнэлгээний төрлүүдийг сонгон авч, үнэлгээ хийсэн талаар тайланд тусгасан байна.

2.1 Байгууллагын чиг үүргийн үнэлгээний талаар:

Үнэлгээний тайлангаас үзэхэд ҮСХ нь Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM)-ыг нэвтрүүлэх хүрээнд 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилтын хүрээнд 90 ажил, тодотголоор 6 ажлыг нэмж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллажээ. Биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлэхэд 88 ажил бүрэн хэрэгжсэн, 5 ажил хэрэгжих шатандаа, 3 ажил хэрэгжилт хангалтгүй байсан тул ҮСХ-ны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 96.0 хувьтай гэж тайлагнажээ.

Тайланд тусгагдсан хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай ажлуудаас тодруулбал:

- Мэдээлэл боловсруулах үйл ажиллагааг автоматжуулах, хялбаршуулах зорилгоор (SPS) системийг нэвтрүүлэн 52 мэдээ, тайланг шилжүүлэхээс 10 мэдээ, тайланг шилжүүлсэн, 33 мэдээ, тайланг шилжүүлэхэд бэлэн болгосон, 9 мэдээ, тайланг боловсруулаагүй;
- Албан ёсны болон захиргааны статистик мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах, тархаах зорилтын хүрээнд 2020 оны 32 танилцуулгыг бэлтгэн тархахаас 7 танилцуулгын тархаагаагүй;
- Ковид-19 цар тахлын улмаас холбогдох ажилтнуудад сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлууд хойшилсон байна.

Хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай ажлууд:

- Салбарын бодлогын зохицуулалтыг хангах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд боловсруулсан Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өөрчилж, УИХ-д өргөн барих ажлыг хойшлуулж, 2022 оны төлөвлөгөөнд шилжүүлсэн байна;
- Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтээр тооцоо, загварчлал, шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд өгөгдлийг ашиглах туршилтын явцад хэрэглээний үнийн индексийг тооцоход статистик алдаа их гарсан байна. Иймд 2021 оны сүүлийн хагас жилийн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнтэй хамтад нь нэмж тооцоолол хийхээр хойшлуулсан байна;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах зорилтын хүрээнд ажлын хэсгийг байгуулж бодлогын баримт бичгийг боловсруулах ажил 30 хувьтай байна.

2.2 Хүний нөөцийн үнэлгээ:

ҮСХ-ны даргын 2021 оны А/115 дугаар тушаалын дагуу нийт 8 нэгжид 123 ажилтан, 21 аймаг, нийслэл хот, түүний 8 дүүргийн статистикийн газар, хэлтэст 197 ажилтан, нийт 320 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Статистикийн анхан шатны мэдээ, тайлан, тооллого судалгааг хариуцдаг багийн Засаг дарга нарын 28.4 хувь нь мэргэжилгүй, 54.4 хувь нь бусад мэргэжлийн байна. Мөн нийт багийн Засаг дарга нарын 21.4 хувь нь албан хэрэгцээнд ашиглах компьютергүй байгаа бол компьютертой 846 багийн даргын 57.0 хувь нь ажлын шаардлага хангахгүй компьютертой ажиллаж байна. Мөн Засаг дарга нар тайланг хоцроодог, компьютер, програм ашиглах чадвар муу байгаа тул зайлшгүй чадавхижуулах шаардлагатай байгаа талаар тайланд тусгасан байна.

“Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-д шинэчлэлт хийхдээ багийн Засаг дарга нарын 17.6 хувь нь ЗДТГ-ын ажилтнуудын ашиглаагүй байгаа сул компьютер, 12.9 хувь нь хувийн компьютер ашиглаж байгаа нь мэдээллийн нууцлал алдагдах эрсдэлтэй байгаа талаар дурджээ.

Харин Нийслэл хотын 169 хорооны албан хаагчдын 16.3 хувь нь магистр, 83.7 хувь нь бакалавр болон дипломын дээд боловсролтой бөгөөд 70.5 хувь нь 5-аас дээш жилийн ажлын туршлагатай байна.

Архив болон албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т “Байгууллага архивын орон тооны ажилтантай байх...”, 35 дугаар зүйлийн 35.3-т “Байгууллага орон тооны бичиг хэргийн ажилтантай байна...” гэж тус тус заасан. Тус хуулийн хэрэгжилтийг хангахын тулд 21 аймаг, нийслэл, 8 дүүрэгт архивын ажилтан 1, бичиг хэргийн ажилтан 1 буюу нийт 60 ажилтан шаардлагатай байна.

Албан хаагчдын дунд явуулсан сэтгэл ханамжийн судалгаанд аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн нийт ажилтны 86.3 хувь нь оролцоноос 54.7 хувь нь сэтгэл ханамж их, 41.7 хувь нь цалин бага, илүү цагаар ажилладаг тул дунд, 3.6 хувь нь сэтгэл ханамж бага гэж үнэлсэн байна.

2.3 Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа:

Үндэсний статистикийн хорооны албан хаагчдын цалин Төрийн аудитын байгууллагын салбар нэгжийн албан хаагчийн үндсэн цалингаас сард 628.4-830.0 мянган төгрөгөөр доогуур бөгөөд мэргэшсэн ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд цалинг нэмэгдүүлж багийн Засаг дарга, сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдийг компьютероор хангах, хүчин чадлыг сайжруулах шаардлагатай байгаа талаар тайланд тусгажээ.

Гурав. Байнгын хорооны хурлаар өгсөн заавар чиглэлийн талаар:

Байгууллагын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед өгсөн үүрэг, даалгаврыг тухайн байгууллага үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавих хүрээнд ҮСХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон Эдийн засгийн байнгын хорооны 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг судалж үзлээ.

Байнгын хорооны хуралдаанаар статистикийн мэдээллийн ил тод, үнэн зөв, хурдан шуурхай байх тал дээр анхаарч ажиллах, мөн суурь үнийг 2010 оноор тооцдог байсныг 2015 оноор тооцдог болгох чиглэл өгсний дагуу 2021 оны хоёр дугаар хагаст суурь үнийг 2015 оноор тооцдог болсон байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Статистикийн тухай хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Үндэсний статистикийн хорооны 2021 оны тайланд шинжилгээ хийлээ.

Тамгын газраас дүн шинжилгээг гүйцэтгэхдээ ҮСХ-ноос Статистикийн тухай хуульд заасан чиг үүргээ 2021 онд хэрхэн хэрэгжүүлэн ажилласан талаар авч үзсэнээс гадна “байгууллагын чиг үүргийн хэрэгжилт”, “хүний нөөц”, “байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа”-нд хийсэн системчилсэн үнэлгээг авч үзсэн болно.

ҮСХ-ноос 2021 оны үйл ажиллагааны тайлангаа ирүүлэхдээ Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10-т заасны дагуу Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасан бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлсэн талаар тайланд нарийвчлан дурдаагүй, хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолоос ҮСХ-д өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийн талаар тайлагнаагүй байна. Тухайлбал,

Статистикийн тухай хуулийн:

- 12 дугаар зүйлийн 12.3.2-т заасан “албан ёсны статистикийн үзүүлэлтийг тооцох, тооллого, судалгаа явуулах талаар ойрын зорилтыг тодорхойлсон хөтөлбөрийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах”;
- 12.3.9-д “Засгийн газар, түүний байгууллагын цаг үеийн бодлого боловсруулах, төлөвлөлт, удирдлага зохицуулалт, хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээллийг бэлтгэж өгөх”;

- 12.3.16-д “хуулийн этгээдийн албан ёсны статистикийн мэдээллийн үнэн зөвийг шалгах, илэрсэн дутагдал, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах замаар статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах”;
- 12.3.18-д “Засгийн газрын гишүүн, төрийн бусад албан газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аж ахуйн нэгжийн удирдлагаас гаргасан шийдвэр нь статистикийн хууль тогтоомжтой нийцээгүй бол энэ тухай тэдгээрийн харьяа дээд шатны байгууллагад мэдэгдэж хүчингүй болгуулах арга хэмжээ авах”;
- 12.3.21-д “статистикийн мэдээллийн хэрэглэгч нь албан ёсны статистикийн мэдээллийн дүн өөрчлөн, олон нийтэд буруу ташаа мэдээлэх тохиолдолд албан ёсны тайлбар хийж, залруулах” зэрэг хуульд заасан зарим чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тайланд дурдаагүй болно.

Цаашид Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10-т заасны дагуу ҮСХ нь тухай жилийн үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд ирүүлэхдээ Статистикийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэн ажилласан талаар тайлагнах шаардлагатай байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР